



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ ДЭД
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

Үндэсний хэмжээнд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн явц, хэрэгжилт, үр дүнд нутгийн захиргааны байгууллага анхаарах шаардлагатай байна.

Аудитын код: ДГА-2023/37-1-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2023 оны 07 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Агуулга.....	1
Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёог.....	3
Дүрслэлийн товъёог.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4-5
Ерөнхий мэдээлэл.....	5
БҮЛЭГ А. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байгаа ч зорилт нь бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй байна	6
А.1. Үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хангагдаж байна.....	6
А.1.1. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.....	6-7
А.1.2. Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн зорилт, арга хэмжээг тусгаж хэрэгжүүлээгүй байна.	7-11
БҮЛЭГ Б. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.	11
Б.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг бодитой төлөвлөж, эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.....	11
Б.1.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй боловсруулсан байна.....	11-13
Б.1.2. БОХНС арга хэмжээний зардлаас 50.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	13-15
Б.1.3. Орон нутагт байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхой бус байна.....	15-18
Б.2. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.....	18
Б.2.1. Хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох ажил хийгдээгүй байна.	18-19
Б.2.2. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй, иргэд олон нийтийн оролцоог хангаагүй байна.....	19
Б.2.3. Дэд хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн үр дүнг иргэд, олон нийтэд хүргэх ажил хангалтгүй байна...	19-20
Аудитын дүгнэлт.....	21
Аудитын зөвлөмж.....	22-23
Холбогдох байгууллагын санал.....	24-26
Тайлан баталгаажуулсан тушаал	27

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОХНС	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
ОНТ	Орон нутгийн төсөв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ТЖҮЧ	Таван жилийн үндсэн чиглэл

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт № 1	Үндэсний хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээ нь МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байдал
Хүснэгт № 2	Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг Дорноговь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан байдал
Хүснэгт № 3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө /2018-2022 он/
Хүснэгт № 4	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсэг
Хүснэгт № 5	БОХНС арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт № 6	БОХНС арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэл тус бүрээр

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График № 1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндэсний хөтөлбөрүүдийн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөсөн байдал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн "Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	"Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн зорилт хангагдсан эсэх; 2. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн зарцуулалт, түүнд тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
Аудитын хүрээ	хамрах Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг байгууллагуудын 2018-2022 оны үйл ажиллагааг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, “Нийцлийн аудитын заавар, аргачлал” (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: 1. Үндсэн хууль 2. Төсвийн тухай хууль 3. Засгийн газрын тухай хууль 4. Төрийн хэмнэлтийн тухай хууль 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

	6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 7. Шилэн дансны тухай хууль 8. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 9. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого / УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол/ 11. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол/ 12. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/ 13. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" 14. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалууд 15. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актууд
Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын арга зүйгээр ханган, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Ариунбаатар нар гүйцэтгэв. Аудитын дэд хөтөлбөр, төлөвлөгөөг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлуулж, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж, тайланг 2023 оны 07 дугаар сарын 07-ны дотор боловсруулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлээ.
Ерөнхий мэдээлэл	Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6 дугаар зүйлд заасан Ногоон хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд үндэсний дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа дээрх хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан байна. байна. Үүнд: ✓ Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр; ✓ Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр; ✓ Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр; ✓ Ус үндэсний хөтөлбөр; ✓ Нэн ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр; ✓ Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр; ✓ Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр; ✓ Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр; ✓ Тэрбум мод үндэсний хөдөлгөөн; ✓ Нөхөн сэргээлт-2024 арга хэмжээ.

БҮЛЭГ А. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байгаа ч зорилт нь бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй байна.

А.1. Үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хангагдаж байна.

А.1.1. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж тодорхойлсны дагуу байгаль орчны салбарын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна гэсэн үндсэн зарчмыг баримтлан, байгаль орчны талаар “Ногоон хөгжил” бодлогын хүрээнд МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д 4 зорилтын 41 үйл ажиллагааг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-д 4 зорилтын 18 үйл ажиллагааг, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 9 зорилтын 12 үйл ажиллагааг, “МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-д 20 үйл ажиллагааг, “МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-д нийт 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан байна.

МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт, дунд, богино гэсэн төрөлтэй байна”, 6.5.4-т “Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх байгаль орчны зорилтот хөтөлбөр байна” гэж заасан байна.

Байгаль орчны чиглэлээр 2018-2022 онд дараах үндэсний хөтөлбөрүүд хэрэгжсэн байна. Тухайлбал:

- “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр /Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоол/
- “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” /Засгийн газрын 2010 оны 90 дүгээр тогтоол/
- “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр” /ЗГ-ын 2015 оны 325 дугаар тогтоол/
- “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр” /Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоол/
- “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” /Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоол/
- “Ус” үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2010 оны өдрийн 24 дүгээр тогтоол/
- “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” /Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоол/
- “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр” /Засгийн газрын 2006 оны 99 дүгээр тогтоол/
- “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” /Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоол/
- “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” /Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол/

МУИХ-ын 2020 оны 52 тогтоолын 2 хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, МУИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, МУИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, МУИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэхээр баталсан үндэсний хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдсан талаар харуулав.

**Үндэсний хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээ нь
МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байдал**

Хүснэгт №1

№	Хөгжлийн бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	"Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
1	"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр	Зорилт	3	3	2	1
		Арга хэмжээ	11	4	2	3
2	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	Зорилт	1	1	2	1
		Арга хэмжээ	4	4	4	4
3	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	Зорилт	2	3	4	1
		Арга хэмжээ	10	12	9	7
4	Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр	Зорилт	1	1	2	1
		Арга хэмжээ	3	2	2	1
5	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	Зорилт	1	1	2	1
		Арга хэмжээ	5	4	3	2
6	Ус үндэсний хөтөлбөр	Зорилт	2	3	2	1
		Арга хэмжээ	15	6	6	5
7	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөбөр	Зорилт	2	1	1	1
		Арга хэмжээ	6	2	3	1
8	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	Зорилт	1	1	1	1
		Арга хэмжээ	5	2	2	2
9	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	Зорилт	1	1	1	1
		Арга хэмжээ	3	3	2	3
10	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Зорилт	2	1	1	1
		Арга хэмжээ	5	4	4	4
Нийт дүн		Зорилт	16	16	18	10
		Арга хэмжээ	67	43	37	32

Эх үүсвэр: Үндэсний хөтөлбөрүүд, МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүд

“Алсын хараа-2050”-д байгаль орчны чиглэлээр нийт 16 зорилт, 67 арга хэмжээ, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 16 зорилт, 43 арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 18 зорилт, 37 арга хэмжээ, ЗГ-ын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт 10 зорилт, 32 арга хэмжээг тусгасан ба Үндэсний хөтөлбөрүүдэд дээрх зорилт арга хэмжээг уялдуулан тусгаж баталсан байна.

А.1.2. Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн зорилт, арга хэмжээг тусгаж хэрэгжүүлээгүй байна.

МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.1 "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт, дунд, богино гэсэн төрөлтэй байна", 6.5.4 "Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх байгаль орчны зорилтот хөтөлбөр байна", 6.7 "Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна", 6.8 "Богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг

даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна”, 6.9 "Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө", 9.10.4 "Аймгийн Засаг дарга нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй" гэж тус тус заасан.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь байгаль орчны чиглэлээр 2018-2022 онуудад нийт 9 үндэсний хөтөлбөр, 1 үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэн ажилласнаас тусгай хамгаалалттай газар нутгийн болон ус үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуусаж, МУИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон байна.

Дорноговь аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Ногоон Дорноговь” зорилтот хөтөлбөр баталсан ч МУЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн батлагдаж, Дорноговь аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 56 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөр батлагдсанаар Ногоон Дорноговь хөтөлбөрийг хүчингүй болгосон байна.

Дорноговь аймагт байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрүүдийг орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байгаа байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

**Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг
Дорноговь аймгийн дунд болон богино хугацааны
бодлогын баримт бичигт тусгасан байдал**

Хүснэгт №2

№	Хөтөлбөрийн нэр	Хүчин тэй эсэх	Зорилт, арга хэмжээний тоо		Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны ТЖҮЧ	Аймгийн ЗД-ын 2020-2024 оны ҮАХ	Аймгийн 2021 оны жилийн төлөвлөгөө	Аймгийн 2022 оны жилийн төлөвлөгөө
			Зорилт	Арга хэмжээ				
1	"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр	Тийм	6	19	1	3	2	2
2	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	Тийм	15	50	1	2	3	1
3	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	Тийм	14	29	1	1	2	-
4	Нэн ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр	Тийм	5	36	-	-	-	-
5	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	Үгүй	10	33	1	2	2	1
6	Ус үндэсний хөтөлбөр	Үгүй	6	30	1	6	4	4
7	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	Тийм	5	22	1	2	2	3
8	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Тийм	4	28	-	-	-	2
9	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	Тийм	5	11	1	2	2	3
10	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	Тийм	5	58	-	1	2	1
Нийт			75	316	7	19	19	17

Эх үүсвэр: Үндэсний хөтөлбөрүүд, аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг

Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл:

1."Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр: Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хийж, ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд 50.0 сая төгрөгийг төлөвлөж, 44.8 сая

төгрөгийг зарцуулсан, тухайлбал “Борхойн Баян Бүрд” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн талбайн хүлэмжид говийн ховор ургамлууд болох хармаг, сухай, жигд зэрэг 3 төрлийн үр, суулгацын нөөцийг бүрдүүлсэн байна.

2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр: Хавар, намрын мод тарих аяны хүрээнд аймгийн хэмжээнд нийт 45.5 га талбайд 91,186 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр суулгасан модны тоо 3 дахин нэмэгдсэн, мөн 6 сумын нутагт эвдрэлд орж орхигдсон 75.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр: Амьтны тархац, нөөцийн судалгааны ажлыг Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 44.8 сая төгрөгөөр санхүүжүүлж төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

4. Нэн ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр: Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй.

5.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр: Алтанширээ, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ сумын нийт 90869.7 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар тусгагдсан газруудаас 10 газрыг хамгаалалтад авахаар төлөвлөж Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 24 байршил газрыг 22.8 сая төгрөгийн санхүүжилтээр тэмдэгжүүлэн, тусгай хамгаалалттай 31 газрын 584,037.51 га талбайн хамгаалалтыг сайжруулах зорилгоор 55 идэвхтэн байгаль хамгаалагч томилон ажиллуулсан байна.

6. Ус үндэсний хөтөлбөр: Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд 2 суманд 6 худаг, уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож, хашаажуулан, тэмдэгжүүлж, 3,681.1 сая төгрөгийн санхүүжилтээр 6 сумын ундны усны худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулан, хашаажуулах, камержуулах ажлыг зохион байгуулсан байна.

7. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр: Нийтийн цэвэрлэгээг 45 удаа хийж 6000 га талбайн 1500 тонн хаягдлыг цэвэрлэн хогийн цэгт төвлөрүүлсэн, Улаанбадрах сум орон нутгийн хөгжлийн сангийн 71.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 0.35 га хог хаягдлын төвлөрсөн цэгийг дарж булшлах, шинээр байгуулах ажлыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 300 орчим иргэд, 60 аж ахуйн нэгж байгууллага хогоо ангилж цуглуулснаар хуванцар 160 тонн, гялгар нийлэг материал 50 тонн, цаас 20 тонн, лааз 15 тонн, шил 11 тонн, төмөр 300 тонн, нийт 556 тонн дахивар хаягдлыг Сайншанд Эко говь үйлдвэр болон Улаанбаатар хотын дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэн ажилласан байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/:

1. Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар өрнүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 20 сая мод тарих зорилт тавин орон нутгийн байгууллагууд, иргэд, ААНБ, зэвсэгт хүчний ангиуд нийт 374,949 ширхэг мод тарьж, хашаатай өрх бүрийг 5-аас доошгүй модтой болгох зорилгоор 30.0 сая төгрөгийн шагналын сантай “Ногоон Дорноговь” аяныг зарлаж, 80 өрх, 5 аж ахуйн нэгж байгууллага орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн ургуулах боломжтой олон төрлийн мод тарьж ургуулсан 5 иргэн, 2 аж ахуйн нэгжийг шалгаруулан урамшуулсан урамшуулсан байна. Хавар, намрын мод тарилтаар давхардсан тоогоор 3,244 өрх, 712 ААНБ, 10,043 иргэн нийт 45.5 га талбайд 261,095 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн ажилласан байна.

2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр: Байгаль орчны судалгаа, шинжилгээний “Жэмр” ХХК-тай 2021 онд гэрээ байгуулан, 13 сумын нутагт эвдэрсэн газрын тооллого,

судалгааны ажлыг гүйцэтгүүлж, 148 байршил газрын 3,545 га талбай бүртгэлд хамруулан, тооллого, судалгааны үр дүнг танилцуулах, байгаль орчин, уул уурхай, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна. Тус төлөвлөгөөний хүрээнд уул уурхайн дүйцүүлэн хамгаалах, төмөр замтай холбоотой 460.8 га талбайд 356.5 сая төгрөгийн зардлаар техникийн нөхөн сэргээлт, уул уурхайн компаниуд дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийн хүрээнд техникийн 18.32 га, биологийн 2 га талбайд 87.4 сая төгрөгийн хөрөнгөөр нөхөн сэргээлт тус тус хийж орон нутагт хүлээлгэн өгсөн байна.

3. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр: Ховор бутлаг ургамлын үрийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, хайлаас модны үр, загийн үр, сухай модны мөчир бэлтгэж, үр, суулгацын нөөцийг бүрдүүлж нийт 55,7 га талбайд мод үржүүлгийн газар шинээр ашиглалтад оруулан, говийн унаган ургамал заг, сухай, алтан харгана, буйлс, хайлаас, улиас зэрэг модны 1,4 сая гаруй үрсэлгээг амжилттай хийж, хаврын тарилтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан байна.

4. Нэн ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр: Дорноговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр: Сайншанд сумын нутаг дэвсгэрийн усан хангамжийн эх үүсвэр болох газрын доорх усны ордын тэжээгчийн мужийг усан сан бүхий байгалийн нөөц газрын ангиллаар аймгийн тусгай хамгаалалтад авсантай холбоотой хамгаалалтын дэглэм мөрдүүлэх ажилд хяналт тавьж, сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна. Мөн сумын ИТХ-ын 2022 оны 7/39, 7/40, 7/41 дугаартай “Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай” тогтоолуудаар гурван байршилд нийт 28,476.23 га газрыг байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий түүх соёлын дурсгалт газар ангиллаар 30 жил орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна.

6. Ус үндэсний хөтөлбөр: Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах, гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 18.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 байршилд, “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал”-ын 22.5 сая төгрөгийн санхүүжилтээр 6 байршилд, Хатанбулаг сумын ОНХС-ийн 5.3 сая төгрөгийн санхүүжилтээр 1 байршилд, Иххэт сумын нутагт 1 байршилд, Улаанбадрах сумын 1 байршилд, Даланжаргалан сумын тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд Усны газрын 5.3 сая төгрөгийн санхүүжилтээр 1 булаг, “Эко хэлхээ” ХХК-ийн 2.0 сая төгрөгийн санхүүжилтээр 1 булаг, Айраг сумын ОНТ-ийн 3.5 сая төгрөгийн санхүүжилтээр 1 булаг нийт 16 булгийн эхийг 56.6 сая төгрөгөөр хашаажуулж хамгаалсан байна.

7. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр: Аймгийн 5 сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг түрж булшлах, 5 суманд улс, орон нутгийн 892.8 сая төгрөгийн хөрөнгөөр хог зөөврийн 19 автомашин шинээр худалдан авсан, мөн Сайншанд суманд хэрэгжиж байгаа Эко говь төслийн хүрээнд ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах, Айраг, Иххэт, Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ, Сайхандулаан, Хатанбулаг сумдаас хуванцар, гялгар нийлэг материал, цаас, лааз, шил зэргийг ангилан цуглуулж дахин боловсруулсан ба 450 гаруй сандал, хашааны шон, таг, авто зогсоолын хөдөлгөөн хязгаарлагч зэргийг үйлдвэрлэсэн байна.

Аймгийн 2021, 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө:

Дорноговь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө нь 2021 онд байгаль орчны чиглэлээр 9 зорилт, 21 үйл ажиллагаа, 2022 онд 9 зорилт, 16 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан баталсан ба дээрх хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээг бүрэн тусгаж, хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоол “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн 3.3.1.3-т “нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон ан амьтны менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ”, 3.3.1.4-т “ан амьтны менежментийн төлөвлөгөөг үндэслэн нэн ховор, ховор амьтны байршил нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн орон нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагад хариуцуулан хамгаалах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлж, хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Дорноговь аймагт ан агнуурын менежментийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар орон нутгийн бодлогын баримт бичигт тусгаагүй орхигдуулсан байна.

БҮЛЭГ Б. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Б.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг бодитой төлөвлөж, эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Б.1.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй боловсруулсан байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна”, 20.2-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, бусад эх үүсвэртэй байна” гэж заасан байна.

Аймгийн ИТХ-аас Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр баталж, аймгийн Засаг дарга тухайн жилд хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг баталсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө /2018-2022 он/

Хүснэгт №3

Тайлант он	Арга хэмжээний тоо	Засаг даргын баталсан задаргаа	Аймгийн ИТХ-ын баталсан Байгаль хамгаалах сангийн зардал	Зөрүү
А	1	2	3	4=3-2
2018	13	165,600.0	165,600.0	-
2019	28	238,481.4	238,481.4	-
2020	40	380,828.2	447,408.2	66,580.0
2021	32	380,760.0	456,760.0	76,000.0
2022	34	817,000.0	1,037,000.0	220,000.0
Нийт	147	1,982,669.6	2,547,194.8	564,525.2

Эх үүсвэр: аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын баталсан байгаль орчны төлөвлөгөө

Аймгийн Засаг дарга нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг батлахдаа ИТХ-аас батлагдсан дүнгээс

бага дүнгээр баталсан, тухайлбал 2020 онд 66.6 сая төгрөг, 2021 онд 76.0 сая төгрөг, 2022 онд 220.0 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй баталсан байна.

График №1



Байгаль орчны чиглэлээрх хөтөлбөрүүдийн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд тусгаж байгаа хэдий ч, дараагийн жилийн төсөвт тусгуулах саналыг оруулдаггүй байна.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.9-д “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-А маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна”, 3.10-т “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.8, 3.9-д заасан нийт арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-6-А маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусган батлуулж, биелэлтийг ханган ажиллаж байгаа хэдий ч хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулахгүй байна. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын тооцоо, судалгааг журамд заасан маягтаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэхгүй аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг дараа онд аймгийн Засаг даргаар батлуулж байгаа нь хэрэгжүүлэх арга хэмжээ орхигдох, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх зэрэг эрсдэл үүсэж байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.12-т “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, төлөвлөгөөг төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ” гэж заасан байна.

Дорноговь аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн сүүлийн 2 жилийн гүйцэтгэлийг авч үзэхэд 2021 онд 107.7 сая төгрөгөөр, 2022 онд 183.3 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсэг

Хүснэгт №4 /сая төгрөг/

Тайлант он	БНАТ-ын орлогын дүн		БНАТ-ын орлогын хэсгийн дүн		Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2021 он	1,811.50	1,824.00	351.10	458.80	12.50	107.70
2022 он	8,654.10	8,758.00	1,496.20	1,679.50	103.90	183.30
Нийт	10,465.60	10,582.00	1,847.30	2,138.30	116.40	291.00

Цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны А/35 тоот захирамжаар “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын тооллогыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд 13 сумын 148 байршилд байрлах 3,545 га газрыг бүртгэж, 7.3 тэрбум төгрөгөөр нөхөн сэргээх зардлын тооцоо гарсан байхад эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2020 онд 75.0 сая төгрөг, 2021 онд 45.0 сая төгрөг, 2022 онд 20.0 сая төгрөгийн төсөв батлагдсан хэдий ч тус зардлаар нөхөн сэргээх ажил хийгдээгүй, харин тус ажлыг уул уурхайн компаниуд, ОНХС, НСС-ийн хөрөнгөөр нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн байна.

Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын давсан хэсгийг холбогдох журамд заасны дагуу аймгийн байгаль орчны чиглэлээр тулгамдаж байгаа нөхөн сэргээлт болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөх боломжтой байна.

Б1.2. БОХНС арга хэмжээний зардлаас 50.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.1-т “Аймаг, нийслэлийн засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.2-т “Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна” гэж тус тус заасан.

Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрүүдээс Дорноговь аймгийн хэмжээнд 9 хөтөлбөр, 1 хөдөлгөөнийг хэрэгжүүлж, тус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг аймгийн ИТХ-аар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардалд батлуулж, хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг аймгийн Засаг дарга жил бүр батлан, дараах байдлаар зарцуулсан байна.

БОХНС арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №5

Огноо	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/ Хэтрэлт, хэмнэлт
2018 он	13	165.6	164.3	1.3
2019 он	28	238.5	238.2	0.3
2020 он	41	380.8	17.5	363.3

2021 он	29	380.8	282.8	98
2022 он	19	817.0	699.8	117.2

БОХНС арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэл тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №6

/сая төгрөг/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах сургалт сурталчилгаа, бусад	10.0	6.0		26.9	10.8
2	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хангах	23.0	34.2		38.5	444.9
3	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах	20.0	20.8		41.7	174.4
4	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын талаар	18.0	59.0	17.5	88.5	32.0
5	Ойн нөөцийн хамгаалалт, ашиглалтын талаар	1.0	1.0		50.2	
6	Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах	15.0	2.0		14.4	10.0
7	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар	10.0	20.0		5.3	27.8
8	Салбар дундын зохицуулалт, уялдааг хангаж хамтран ажиллах талаар	5.0	57.3			
9	Нөхөн сэргээлт	53.3	30.0			
10	Хяналт шалгалт	4.0	3.9			
11	Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, ажилчдад дэмжлэг	5.0	4.0		17.4	
Дүн		164.3	238.2	17.5	282.9	699.9

Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.2 "Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна", 3.5, 3.6-д "Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ", 3.7 "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж тус тус заасан.

Гэтэл дээрх заалтуудыг зөрчин аудитад хамрагдсан хугацаанд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, байгууллагад шаардлагатай байгаа тоног төхөөрөмж худалдан авахад нийт 26.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Мөн аялал жуулчлалыг хөгжүүлэх, салбар дундын зохицуулалт, уялдааг хангаж хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор үзэсгэлэнд оролцох, аялал жуулчлалын зөвлөгөөн зохион байгуулах, Шамбала төсөлд дэмжлэг үзүүлэх зэрэг зардалд нийт 33.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/443 захирамжаар тусгай хамгаалалттай газар нутгийн 2018-2022 оны стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 10.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын захиалагчийн эрхийг БОАЖГ-т шилжүүлж, улсын тусгай хамгаалалттай Бүрдэнэ булгийн хилийн цэгийг тэмдэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхдээ тус ажилд 8.0 сая төгрөгийг зарцуулж, харин 2.0 сая төгрөгөөр Хилийн 0168 дугаар ангид гэр худалдан авч өгсөн байна.

Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд аудитын хамарсан хугацаанд нийт 57.7 сая төгрөгийг зарцуулсан байх ба тус зардлын 30.6 хувь буюу 15.8 сая төгрөгийг сургалтын хоолны зардалд зарцуулсан байна.

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.7 “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин БОХНС арга хэмжээний зардлаас зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитаар албан шаардлага тогтоосон.

Б.1.3. Орон нутагт байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхой бус байна.

Төсвийн тухай хуулийн 14.2.11 “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар. төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Дорноговь аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг хөтөлбөрийн зорилготой харьцуулж авч үзвэл:

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр - ийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад чиглэгдсэн байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аудитын хамрах хугацаа II үе шатанд хамрах бөгөөд энэ хугацаанд зорилгын 2015-2025 он/-нд эхний үе шатны үйл ажиллагааны явц, байдалд үнэлэлт дүгнэлт өгч, үндэсний чадавхыг бэхжүүлсний үндсэн дээр нийт ажлын 30-аас доошгүй хувийг гүйцэтгэж, үр дүнг сайжруулсан байхаар тусгасан байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд Сайншанд суманд 2, Замын-Үүд суманд 1, нийт 3 мод үржүүлгийн газарт Ойн ангийг байгуулан орон нутгаас санхүүгийн дэмжлэг үзүүлж, суулгац, говийн ховор модыг тариалсан, Сайншанд сумын төв зам дагуу 600 гаруй мод, Сайншанд сумаас Замын-Үүд сум руу явах туслах авто замын дагуу 3 га газарт 500 ширхэг сухай, Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбогдуулан “Монголиан диндралоги парк” ХХК нь Газрын тос боловсруулах үйлдвэрээс Сайншанд хот хүртэл авто зам дагуу ногоон зурвас байгуулж 2.0 мянган мод нэмж тариалсан, Сайншанд спорт цэцэрлэгт хүрээлэн, Буянт ухаа цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулан 25 төрлийн 60.0 мянган модыг 6510 хүний оролцоотойгоор тариалж, таригдсан модны тоо нь өмнөх онуудаас 36.7 хувиар өссөн байна.

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилтөд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд Дорноговь 80 цогцолбор, Аврагчийн төгөл, Хамрын хийдийн Дунд усны цэцэрлэгт хүрээлэн /3.5 га/, Гэр бүлийн талбай, Дэнжийн цэцэрлэгт хүрээлэн, Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, 80 айлын цэцэрлэгт хүрээлэн зэрэг цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж, нийт 127.9 га талбайд 265.6 мянган модыг тариалж цөлжилтийг сааруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 24 удаа явуулсан. Нийт 166 пуужин буюу 120 гр реагентээр

үүлэнд нөлөөлж нийт нутгаар хур тунадсыг 1,0-32,4 мм-ээр нэмэгдүүлж, 61082.751 м3 усыг газрын гадаргууд буулгасан, Хулан адуу, хар сүүлт зээр, аргаль хонь, янгирын тархац нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 суманд нийт 14 хөв цөөрөм байгуулсан байна.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэх явдал бөгөөд биологийн төрөл зүйлийг хамгаалах, ашиглалтыг тогтворжуулах талаар орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал аймгийн зарим нутаг дэвсгэрт тарвага сэргээн нутагшуулах зорилгоор “Их нартын хамгаалалтын захиргаа”-тай хамтран тарвага сэргээн нутагшуулахад тулгарах “Биотик болон аботик хүчин зүйлс”-ийн судалгааны ажлыг хийсэн, мөн том хөхтөн амьтдын судалгааны ажлыг хийж, энэ ажилд хөрөнгө зарцуулж ирсэн. Цаашид махан идэшт болон мэрэгч, хэвлээр явагч, жигүүртэн, цаашлаад ургамлын судалгааны ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна.

Нэн ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлж, байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөлийг нь хангах, зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгой, тархац нутгийг нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Тус хөтөлбөрийн хүрээнд ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгээс 2016, 2017 онуудад төмөр замын дагуух зэрлэг амьтны хорогдол, төмөр замын гарц, ус зайлуулах хоолойн тоо мэдээг гаргах, тор авах болон өргөст торыг солих газруудыг тодорхойлох судалгааны ажлыг зохион байгуулсан. 2019 оны 05-р сард Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн төмөр замын 914 дугаар км-т 500м, 958 дугаар км-т 700м нийт 1.2 км замын өргөст торон хашааг авч зэрлэг амьтны нүүдлийн замыг чөлөөлж, хөдөлгөөн мэдрэгч 85 камер суурилуулан мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг судлах ажлыг хийснээр зэрлэг амьтад чөлөөтэй шилжин нүүдэллэх боломжийг бүрдүүлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоолын дагуу ховор ангилалд багтах хулан адуу, аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээр тархан нутагшиж байгаа ба 2016 онд Аргаль хонины тархац нутгийн 59,3 хувь, янгир ямааны тархац нутгийн 56,4 хувь, Хар сүүлт зээрийн тархац нутгийн 34,9 хувь, Хулан адууны 22,1 хувь, 2019 оны байдлаар Аргаль хонины тархац нутгийн 44 хувь, Янгир ямааны тархац нутгийн 66.6 хувь, Хар сүүлт зээрийн тархац нутгийн 53.8 хувь, Хулан адууны тархац нутгийн 50 хувийг тус тус улс болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Ус үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь Монгол орны усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан улс орны хөгжлийн түлхүүр болгох, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Аймгийн хэмжээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг 316 булагт 11774.97 га-аар тогтоон хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэн, АИТХ-ын 2019 оны 10/02, 10/04, 10/07, 10/13 дугаар тогтоолоор 4 сумын 42,097.1 га газрыг аймгийн тусгай хамгаалалтад авсан, нийт 6 суманд шинээр 7 булгийн эхийг хашиж хамгаалж, 1 булгийн хашааг засаж тохижуулан, усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажил хийгдсэн байна. Говийн бүсийн газрын доорх усны хяналтын сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд Сав газрын захиргаад нийт 21 мониторингийн цооногийг тоноглон хяналтын тоног төхөөрөмж суурилуулсан төдийгүй Сайншанд сумын 2-р багт 3000 м3/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд

хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/312 дугаар захирамжаар аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулж нийт 32 аж ахуйн нэгж байгууллагад хадгалагдаж байгаа 130 нэр төрлийн 66.4 тн хатуу, 31.6 тн шингэн хаягдлыг бүртгэж тооллогод хамруулсан, 37 байршилд дахивар хог хаягдлыг 3 төрлөөр ангилан ялгах зориулалтын савыг байршуулж 60 гаруй аж ахуйн нэгж, иргэд дахивар хаягдлыг ангилж цуглуулан хуванцар 75 тонн, гялгар нийлэг материал 40 тонн, цаас 15 тонн, лааз 20 тн, шил 50 тн бүгд 200 тн хаягдлыг ангилж цуглуулан Эко говь дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлсэн, аюултай хаягдал түр хадгалах агуулахын барилгыг барьж байгуулсан байна.

Тохижилт Сайншанд хот тохижилтын газартай гэрээ байгуулан ажиллаж Сайншанд сумын 3 байршилд 123.5 га талбай зориулалтын бус газарт үүссэн олон жил хуримтлагдсан 20.0 мянган м3 хур хог хаягдлыг цэвэрлэж аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 25.0 сая, БОАЖЯам-Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос аймгуудад хуваарилсан 50.0 сая төгрөгөөс 30.9 сая нийт 55.9 сая төгрөг зарцуулсан.

Сайншанд суманд Эко говь төсөл санаачлан хэрэгжүүлэгч 2 иргэнийг дэмжин Хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж БОАЖГ-аас 54.6 сая төгрөгийн үнэтэй хуванцар хаягдлыг бутлагч, преслэгч, хуванцар гялгар хаягдлыг хайлуулах тоног төхөөрөмж, ангилсан хог хаягдлыг нөөцлөх контейнер, жин, камер зэрэг төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ажиллаж эхэлсэн байна.

Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр-ийн зорилго нь Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн.

Хөтөлбөрийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 481 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн хэмжээнд 2302 өрхийн 1,364,150.10кВт.ц ашиглалтад 103.7 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн цахилгаан халаалтыг ашиглахад дэмжлэг үзүүлсэн, сумдын төвийн нийт 31 аж ахуйн нэгж байгууллага, 220 айл өрх цэвэр бохирын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, Мандах, Замын-Үүд, Эрдэнэ сумдын төвийн 97 айл өрх стандартын шаардлага хангасан соруулдаг нойлтой болж 31 айл өрх хуучин ашиглаж байсан нүхэн жорлонгоо дарж булшилж ариутгасан байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн-ийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, төв суурин газрын тохижилтыг сайжруулах, хүн, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн цэвэр орчинд амьдрах орчныг бүрдүүлэх ажлыг аймаг, сум, баг, орон нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөн хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд 20 сая мод тарьж ургуулахаар зорилго дэвшүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтод хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 461 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын 6441 хүний оролцоотой 289,540 модыг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан эрчимтэй хэрэгжүүлж байгаа хэдий ч усалгаа, арчилгааны асуудлыг эзэнжүүлж хариуцуулах талаар тодорхой бодлого баримталж төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарах шаардлагатай байна.

МУ-ын Засгийн газраас үндэсний хөтөлбөр баталсан тогтоолуудад Үндэсний хөтөлбөрийг эрхлэх ажлын хүрээнд тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхэд

шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Гэтэл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, хүрэх үр дүн тодорхой бус байгаагаас хөтөлбөрийн явц, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Мөн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг улсын төсөвт хангалттай хэмжээгээр тусгаж баталдаггүй, эх үүсвэр хүрэлцээгүй байдгаас шалтгаалан хөтөлбөр тогтвортой, үр дүнтэй хэрэгжихэд сөргөөр нөлөөлдөг байна.

Б.2. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б.2.1. Хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох ажил хийгдээгүй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5¹-д ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр заасан.

Аудитын хамарсан хугацаанд Дорноговь аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тухайлбал аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-ийн хэрэгжилт, аймгийн 2021, 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу баримт бичиг тус бүрээр хэлэлцүүлэн үнэлж дүгнэсэн байна.

Харин аймгийн ИТХ-ын 2022 оны 10/04 дүгээр тогтоолоор аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2022 оны биелэлтийг үнэлсэн байх боловч байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа “Тэрбум мод” зорилтот хөтөлбөрөөс бусад хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг оруулж үнэлээгүй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-т “Нэгжийн удирдлагаар байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлтийн ажлыг төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлнэ, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна”, 40.3-д “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга БОАЖЯ-ны сайдтай 2018-2022 онуудад байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулан ажилласан байна.

Сайдтай байгуулсан гэрээнд 2021 онд нийт 9 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг 380.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээнд 185.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 31 арга хэмжээнд 150.9 сая төгрөгийг зарцуулж, нэмэлтээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2 арга хэмжээг 38.5 сая төгрөгөөр хэрэгжүүлж гэрээг 81.9 хувьтай дүгнүүлсэн байна.

Харин 2022 онд нийт 7 зорилт 40 арга хэмжээг 817.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээнд тусгаснаас, байгалийн нөөц ашигласны төлбөр түүнтэй холбогдох 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээнд 529.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

¹ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх

Гүйцэтгэлээр 19 арга хэмжээнд 520.6 сая төгрөгийг зарцуулж, гэрээний хэрэгжилт 88.9 хувиар дүгнэгдсэн байна.

Аймгийн засаг дарга Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргатай хамтран ажиллах гэрээг байгуулахдаа БОАЖС-тай байгуулсан гэрээ, аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, аймгийн байгаль орчны чиглэлээр батлагдсан менежментийн төлөвлөгөө зэрэгт тусгагдсан арга хэмжээнээс 2021 онд байгаль орчин нөхөн сэргээх үйл ажиллагааны чиглэлээр нийт 6 зорилтын 24 үйл ажиллагаанаас байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааны хүрээнд 3 зорилт 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийн биелэлтийг 87.3 хувиар, 2022 онд 6 зорилт 37 арга хэмжээнээс 3 зорилт 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж, гэрээний хэрэгжилтийг 85.1 хувиар дүгнэсэн байна.

БОАЖГ-аас байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр нэгтгэн орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнасан байх боловч орон нутгийн зүгээс хөтөлбөрийн явц, үр дүнг үнэлэх, дүгнэх асуудал орхигдсон байгаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Б.2.2. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлээгүй, иргэд олон нийтийн оролцоог хангаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27.2.6 "Улсын байцаагч нь байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах үүрэгтэй", 32.1.1 "Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах" гэж заасан.

Аймгийн засаг даргын БОАЖС-тай байгуулсан гэрээний 1.1-т заасан "Байгаль орчныг хамгаалах зөв дадал зуршил бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд Айраг, Даланжаргалан, Хатанбулаг, Мандах, Иххэт, Өргөн, Эрдэнэ сумдад тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалтыг сайн дурын 9 иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамтран ажилласан байна.

Мөн гэрээний 1.5-д заасан "Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд иргэдээс ирүүлсэн мэдээлэл байгаагүй, харин нэр бүхий 12 сумдын нутагт хамаарах орон нутгийн тусгай хамгаалалттай 31 газрын 584,0 мянган га талбайд 55 иргэнийг идэвхтэн хамгаалагчаар татан оролцуулсан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд тухайлсан хяналт хэрэгжүүлээгүй, иргэд, олон нийт, ТББ-уудыг татан оролцуулах ажил хангалтгүй байна.

Б.2.3. Дэд хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн үр дүнг иргэд, олон нийтэд хүргэх ажил хангалтгүй байна.

МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 23.1 "Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна", Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэхэд

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөхийн зэрэгцээ ил тод байх, иргэдийг мэдээллээр хангах зарчмыг баримтална”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т “ Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх зарчмыг баримтална” гэж тус тус заасан байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн арга хэмжээний хэрэгжилт, явцыг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж ажилласан байдлыг авч үзэхэд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, явцыг цахим хуудас болон орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээлэл хүргэх ажил хийгдсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын facebook хуудсанд байршуулсан мэдээлэлтэй танилцахад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, явц, байгаль орчныг хамгаалах талаар цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бэлтгэсэн байгаль орчин, ан амьтан, хог хаягдал, нөхөн сэргээлт, агаарын бохирдол, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг тогтмол байршуулсан боловч орон нутагт хэрэгжиж байгаа бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын талаар мэдээллийг иргэдэд хүргэх ажил хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн зорилтыг МУ-ын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдийн зорилт, арга хэмжээтэй уялдуулан баталж хэрэгжүүлсэн байна.
2. Дорноговь аймагт ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа ч нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар арга хэмжээг орон нутгийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын давсан хэсгийг нэн тэргүүнд тулгамдаж байгаа нөхөн сэргээлт болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж зарцуулах боломжтой байна.
4. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 50.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
5. Орон нутагт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, шалгуур, хүрэх үр дүн тодорхой бус байгаагаас хэрэгжиж дууссан болон хэрэгжиж байгаа хөтөлбөрийн явц, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.
6. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн явц, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг тухай бүр тооцох шаардлагатай байна.
7. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх ажлыг тогтмолжуулж, иргэд, олон нийт, ТББ-ын оролцоог хангах ажлыг зохион байгуулаагүй байна.
8. Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй байна.

Аудитаар нийт 6 зөрчил илрүүлж, зөрчил арилгах, алдааг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 6 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоол “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн 3.3.1.3-т *“нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон ан амьтны менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ”* гэж заасны дагуу нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар орон нутгийн бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх.
2. Аймгийн хэмжээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуурыг тодорхой тусгаж, хэрэгжилтийн явц, үр дүнг бодитой үнэлж дүгнэх. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.3, 7.3-т заасны дагуу тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримтлан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх.
3. МУ-ын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын давсан хэсгийг төлөвлөж АИТХ-аар батлуулах, мөн тус журамд заасан арга хэмжээг зориулалтын дагуу зарцуулахаар шийдвэрлэж байх.

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОТГОНБАЯР ТАНАА:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27.2.6 “Улсын байцаагч нь байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах үүрэгтэй”, 32.1.1 “Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж, хяналтад олон нийтийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.8, 3.9-д заасан нийт арга хэмжээний төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу нэгтгэж төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад хүргүүлж, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 23.1 *"Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна"* гэсэн заалтын дагуу байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн явц, хэрэгжилтийн талаар мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж ажиллах,

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

1. Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар:



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2023.07.07 № 01/913

танай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Танайхаас ирүүлсэн 2023 оны 1-6/509 тоот
албан бичгийг хүлээн авч танилцлаа.

“Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн дэд
хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмжид тусгах
саналгүй болно.

О.БАТЖАРГАЛ

44 6230782

2. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар:



**ДОРНОГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2023.07.07 № 384
танай 2023.07.07-ны № 1-6/508 -т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж саналыг хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт хуудастай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОТГОНБАЯР



442303552

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
2023 оны 07-р сарын 07-ны өдрийн
384 дүгээр албан бичгийн хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

1. Байгаль орчны салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд сумдад ажиллах хүний нөөц, боловсон хүчин хангалтгүй байдаг.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан нормативын дагуу тус аймагт 16 байгаль хамгаалагч ажиллахаар тусгагдсан боловч өнөөгийн байдлаар томилогдсон нэг ч байгаль хамгаалагч байхгүй.
3. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд улс болон орон нутгаас тусгайлсан санхүүжилт байдаггүй.

—ооо—

САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

1. Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд тусгагдсан төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах шалгуур, төрийн захиргааны албан хаагчид олгохоор тогтоосон цалингийн хэмжээ, ажиллах орчин нөхцөлтэй холбоотой орон нутагт ажиллах боловсон хүчин, хүний нөөцийн дутагдалтай байгаа нөхцөл байдал нь орон нутагт тулгамдаж байгаа нийтлэг асуудал бөгөөд энэ аудитаар зөвлөмж өгснөөр тус асуудлыг шийдвэрлэх боломжгүй тул тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.

2. Танай байгууллагаас ирүүлсэн саналын 2, 3-т аймагт ажиллах байгаль хамгаалагч томилж ажиллуулаагүй, хөтөлбөр хэрэгжүүлэхэд улс, орон нутгаас тусгайлсан санхүүжилт олгодоггүй талаар тусгасан байх ба эдгээр асуудлын талаар аудитын тайлангийн Б.1.1, Б.1.3 дахь хэсэгт дурдагдсан бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан байгаль орчныг хамгаалах бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн болно.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/24

Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.2, 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйл 21.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2, 18.9, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.





Т.ГАН-ӨЛЗИЙ

010012107

This PC: D/2021 onii ajil/doc/Тушаал

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.ГАН-ӨЛЗИЙ

У.ОЮУНТҮЛХҮҮР

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:
ГҮЙЦЭТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Э.ЭНХЦЭЦЭГ

Б.АРИУНБААТАР

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

